



МОНГОЛ УЛСЫН  
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/313

Улаанбаатар хот

Батлан хамгаалахын сайдын дэргэдэх  
Ахмадын зөвлөлийг байгуулах,  
зөвлөлийн ажиллах журмыг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Батлан хамгаалахын сайдын 2020 оны А/221 дүгээр тушаалаар батлагдсан “Батлан хамгаалах яамнаас ахмад настны талаар баримтлах бодлого”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Монголын Ахмадын хорооны дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Батлан хамгаалахын сайдын дэргэдэх Ахмадын зөвлөлийг байгуулсугай.
2. Ахмадын зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, зөвлөлийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Батлан хамгаалах яамнаас ахмад настны талаар баримтлах бодлого болон бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Батлан хамгаалах яам /хурандаа Д.Ганхуяг/, Зэвсэгт хүчний Жанжин штаб /хошууч генерал Д.Ганзориг/-т үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /хурандаа Б.Эрхэмбаяр /-т даалгасугай.

САЙД



Г.САЙХАНБАЯР

1320100741

Батлан хамгаалахын сайдын 2020 оны  
12 дугаар сарын 13-ны өдрийн 3 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт



## АХМАДЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН НЭР

Зөвлөлийн дарга:

- Батлан хамгаалах яамны ахмадын хорооны дарга;

Гишүүд:

- Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;
- Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга;
- Зэвсэгт хүчний Жанжин штабын Хүний нөөцийн хэлтсийн дарга;
- Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн захирагч;
- Цэргийн төв эмнэлгийн дарга;
- Багабаян-Энхийн төлөө цогцолбор төв Төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга;
- Зэвсэгт хүчний Жанжин штабын Ахмадын хорооны дарга;
- Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Ахмадын хорооны дарга.

Нарийн бичгийн дарга:

- яамны Ахмадын бодлого, өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэн.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

Батлан хамгаалахын сайдын 2020 оны  
12 дугаар сарын 23-ны өдрийн 34 дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт

## АХМАДЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журам /цаашид “Журам” гэх/ нь Батлан хамгаалахын сайдыг ахмад настны талаар баримтлах бодлого, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд зөвлөх, дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Ахмадын зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/-ийн үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Ахмад настны яс үндэс, нийгмийн гарал, шашин шүтлэг, үзэл бодол, нас хүйс, мэргэжил, боловсрол, эрхэлж байсан ажил, хөдөлмөр зэргээр үл ялгаварлан ахмад настан бүрт тэгш үйлчлэх зарчим баримтална.

1.3. Ахмадын зөвлөл үйл ажиллагаагаа нээлттэй, ил тод явуулна.

### ХОЁР. ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Зөвлөл нь Батлан хамгаалах яамнаас ахмад настны талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангахад чиглэсэн байнгын үйл ажиллагаа явуулна.

2.2. Зөвлөл өөрийн чиг үүрэгтэй холбоотой асуудлаар хурал зохион байгуулна.

2.3. Хурлын тов, хэлэлцэх асуудлыг Зөвлөлийн дарга тогтоож батална.

2.4. Зөвлөл нь үйл ажиллагаагаа Батлан хамгаалахын сайдад танилцуулж байна.

2.5. Цэргийн нэгтгэл, анги, байгууллагын Ахмадын зөвлөл, хороодоор дамжуулан нийт ахмадууддаа авч хэрэгжүүлсэн ажил, үйл ажиллагаагаа тайлагнана.

2.6. Ахмадын зөвлөлийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ.

2.6.1. Батлан хамгаалах яамнаас ахмад настны талаар баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан;

2.6.2. Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний ахмад настны эрхийг хангах, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ авах боломжийг дээшлүүлэх, тэдний нийгмийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулах ажил, арга хэмжээний төсөл;

2.6.3. ахмад настнуудын талаарх судалгаа гаргаж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлон, асуудлын эрэмбийг тогтоож, уламжлах;

2.6.4. бусад.

### ГУРАВ. ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

3.1. Зөвлөл нь 9 гишүүнтэй байх бөгөөд зөвлөлийн гишүүдийг Батлан хамгаалахын сайдын тушаалаар батална.

## ДӨРӨВ. ЗӨВЛӨЛИЙН ЭРХ, ҮҮРЭГ

### 4.1. Зөвлөл нь дараах эрхийг эдэлнэ:

4.1.1.ахмад настны талаар баримтлах бодлого, холбогдох эрх зүйн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, санаачилга гаргах, хууль тогтоомжийн дагуу тухайн асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад уламжлах;

4.1.2.ахмад настны талаар баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих;

4.1.3.цэргийн нэгтгэл, анги, байгууллагын Ахмадын зөвлөл, хороодын үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах;

4.1.4.Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, харьяа цэргийн нэгтгэл, анги, байгууллагын Ахмадын зөвлөл, хороодын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, нэгдсэн зөвлөмжөөр хангах;

4.1.5.Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлалуудын хүний нөөц хариуцсан нэгжтэй хамтран ахмад настны мэдээллийн санг жил бүр баяжуулж, мэргэжлийн бэлтгэл, мэдлэг, ур чадварын судалгааг гарган, үйл ажиллагаандаа ашиглах;

4.1.6.олон улсын байгууллага, гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

4.1.7.бусад.

### 4.2. Зөвлөл нь дараах үүрэг хүлээнэ:

4.2.1.Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлалуудтай хамтран Ахмадын зөвлөл, хороодын үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулах боломжоор хангах;

4.2.2.ахмад настнууд ажлын туршлага, ур чадвараараа нэгдэн хоршоо, нөхөрлөл байгуулах, төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхэд нь төрийн болон төрийн бус байгууллагаас төрөл бүрийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;

4.2.3.ахмадын зөвлөл, хороодоос эмчилгээ, сувилгаа шаардлагатай ахмадуудын судалгааг тогтмол гаргуулж, дарааллын дагуу рашаан сувилал, нөхөн сэргээх эмчилгээ, үйлчилгээнд хамруулах;

4.2.4.тэтгэвэр, чөлөөнд гарсан ахмад настны амьдрал, ахуйд нь санхүү, эд материалын дэмжлэг үзүүлэх асуудлыг шийдүүлэх;

4.2.5.батлан хамгаалах хууль тогтоомжийг боловсруулах, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ахмад настныг оролцуулах;

4.2.6.цэргийн алба, амьдралын баялаг туршлагатай ахмад настнуудыг хүүхэд, залуучуудад цэрэг-эх оронч үзэл, хүмүүжил олгох болон бусад арга хэмжээнд оролцуулах;

4.2.7.ахмад настны спортын баг, соёл, урлагийн хамтлаг, сонирхлын бүлэг, клубийг байгуулах үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;

4.2.8.бусад.

## ТАВ.ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Зөвлөлийн гишүүн дараах эрхтэй.

5.1.1.Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлалаас ахмад настны талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн явц, үр дүнгийн талаарх тайланд дүгнэлт өгөх;

5.1.2.ахмад настны тухай хууль тогтоомж, баримтлах бодлогын хэрэгжилтийн явц, байдлын талаар зөвлөлийн хуралд хэлэлцүүлэхээр санал оруулах;

5.1.3.ахмадын зөвлөлд болон өөрийн харьяаны цэргийн нэгтгэл, анги, байгууллагын ахмадын хороодын үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах талаар санал гаргах, зөвлөлийн хуралдаанд танилцуулах;

5.1.4.хэлэлцэж буй асуудлын талаар асуулт тавих, санал хэлэх, байр сууриа илэрхийлэх, дүгнэлт гаргах;

5.1.5.хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан шаардлагатай мэдээлэл авах, нэмэлт судалгаа хийх;

5.1.6.зөвлөлийн хурлаар оруулж байгаа асуудлын материалыг бүрэн судлах, үндэслэлтэй эсэхийг тодотгох, санал оруулах.

5.2. Зөвлөлийн гишүүн дараах үүрэгтэй.

5.2.1.ахмад настны тухай хууль тогтоомж, баримтлах бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулж, санал хүргүүлэх;

5.2.2.ахмад настны эрхийг хамгаалах үүрэгтэй төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааны уялдаа холбоог хангах талаар хэрэгжүүлсэн ажлын тухай санал, дүгнэлт гаргах;

5.2.3.ахмад настны эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ авах боломж, амьдрах орчин, нөхцөлийг нь сайжруулахтай холбоотой төсөл, хөтөлбөрийг санаачлах;

5.2.4.бусад асуудал.

## ЗУРГАА. ШИЙДВЭР ГАРГАХ

6.1. Зөвлөл гишүүдийн хурлаа улиралд нэгээс доошгүй удаа 2/3-ын ирцтэйгээр хуралдана.

6.2. Зөвлөлийн хурлаас гаргах шийдвэрийг гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

6.3. Хурлаар хэлэлцсэн асуудлыг шаардлагатай гэж үзвэл, буцаах, дахин боловсруулахаар хугацааг тогтоон хойшлуулах хэлбэрээр шийдвэрлэнэ.

6.4. Зөвлөлийн хурлын шийдвэр нь тогтоол, тэмдэглэл байна. Тогтоолд зөвлөлийн дарга, гишүүд; тэмдэглэлд дарга, тэмдэглэл хөтлөгч (нарийн бичгийн дарга) гарын үсэг зурснаар тус тус хүчин төгөлдөр болно.

6.5. Зөвлөлийн даргын санал болгосноор тухайн асуудлаар санал хураалтыг нууцаар болон илээр хураах зарчмаар шийдвэрлэнэ.

6.6. Зөвлөлийн дарга хэлэлцэж буй асуудлаар гаргасан шийдвэрийг Батлан хамгаалахын сайд, холбогдох албан тушаалтанд танилцуулж, салбарын бодлого, шийдвэрт тусгуулах арга хэмжээг авч, үр дүнг тооцно.

--- оОо---